

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 06

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7.1 дэх заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь;

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 261,398,226.52 (хоёр зуун жаран нэгэн сая, гурван зуун ерэн найман мянга, хоёр зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Компанийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, чөлөөлсөн газрыг “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн оффиссын болон үйлчилгээний зориулалтаар ашиглах, газрыг нөхөн сэргээх;

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



С.НЯМБАЯР

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2022 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 11:00-13:40	Уулзалтын газар:	Цахим, Zoom програмаар зохион байгуулагдав. (Zoom ID: 249 198 1234) URL: telecommongolia.mn/news/shm2022
Хурлын дарга:	Содномдовжидын Нямбаяр, МЦХ ХК-ийн Маркетинг борлуулалтын газрын захирал		
Тооллогын комисс:	Дарга: Д.Ганцэцэг, Дотоод аудитын газрын мэргэжилтэн, Гишүүд: С.Цог, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн Б.Хулан, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер		
Ирц:	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,505,887 ширхэг саналын эрх бүхий 13 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.73%		

Оролцсон хувьцаа эзэмшигчид:

Д/д	Хувьцаа эзэмшигч	Регистрийн дугаар	Хувьцааны тоо /ширхэг/
1.	Болдсүхийн Амирлан	УК13301021	10
2.	Болдсүхийн Чингүүн	УК09262098	5
3.	Бямбажаргалын Амартөр	ЦБ87062438	16
4.	СБА ХХК	2611929	6,353
5.	Галт-Очирын Батнасан	УС74092001	15
6.	Баттөмөрийн Ганболд	ЖИ85032413	1
7.	Жадамбагийн Энхтунгалаг	ЧГ58100561	100
8.	BDSEC	2052482	5
9.	Цэрэнлхамын Лхамсүрэн	АЭ76042000	70
10.	Сумъяагийн Уранчимэг	УЖ62022600	20
11.	Раднаабазарын Баасансүрэн	Ш356042018	5
12.	ТӨБЗГ	6098169	10,355,683
13.	Төрийн өмч	AA11111111	14,143,604

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2020 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай;
7. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай

СОНССОН нь:

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Монголын Цахилгаан Холбоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн мэдээлэл 1. Компанийн тухай хуулийн 69.1-д заасан саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор 2.МЦХ ХК-ийн дүрмийн 7.12-д компанийн саналын эрх бүхий хувьцааны 61-ээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид оролцсоноор Хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болно гэж заасан заалтуудыг үндэслэн: Ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 24,505,887 ширхэг хувьцаа эзэмшиж буй 13 хувьцаа эзэмшигч ирж 94.73 хувийн ирцтэй байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

С.Нямбаяр, хурлын дарга: Ирц бүрдсэн байна. Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээснийг мэдэгдье. Одоо би хурлаар хэлэлцэх асуудал, хурлыг дэгийг танилцуулъя.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулж, хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, тайлангийн талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа нар тус тус танилцууллаа.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар танилцуулгыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцууллаа.

Гуравдугаар хэлэлцэх асуудлаар

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт, тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Норовжамц танилцууллаа.

Дөрөвдүгээр хэлэлцэх асуудлаар

4. 2020 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай

Хэлэлцэх асуудлаар 2020 оны ногдол ашиг тараасан тайланг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцуулж, 2021 оны ногдол ашиг тараах эсэх талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолыг танилцууллаа.

Тавдугаар хэлэлцэх асуудлаар

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Хэлэлцэх асуудлаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнийг чөлөөлж, томилох тухай Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол, мөн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны тогтоол, нэр дэвшигчдийн танилцуулгыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Зургаадугаар хэлэлцэх асуудлаар

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийн төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Долоодугаар хэлэлцэх асуудлаар

7. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай

Хэлэлцэх асуудлын танилцуулгыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцууллаа.

Ж.Баасандорж: БНМАУ-ын Засгийн газрын дэргэдэх холбооны ерөнхий газрын даргын 1992 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 10 тоот тушаалаар Монголын харилцаа холбоо компанийг байгуулж, Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 28 тоот тогтоол, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1995 оны 208 дугаар тушаалаар (хувьцааны 54.67 хувийг Монгол Улсын Засгийн газар, 40 хувийг БНСУ-ын Корей телеком корпораци, 5.33 хувийг иргэд) эзэмшихээр Монголын цахилгаан холбоо ХК-ийг байгуулсан байдаг.

Монгол Улсын Засгийн газрын “Цахилгаан холбооны сүлжээний төрийн өмчийн компани байгуулах тухай” 2006 оны 186 дугаар тогтоолын дагуу Монголын цахилгаан холбоо ХК-ийг салган, Монголын цахилгаан холбоо ХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК болгон шинэчлэн зохион байгуулснаас хойш өнөөдрийг хүртэл 16 жилийн хугацаанд Монголын цахилгаан холбоо ХК нь өөрийн байргүй, түрээсийн байранд үйл ажиллагаагаа зохион байгуулсаар ирсэн.

“Монголын цахилгаан холбоо” ХК-ийг 2006 онд өөрчлөн зохион байгуулахад тус компанийн өмчлөлд нийслэл Улаанбаатар хотын төвд 1 үл хөдлөх хөрөнгө буюу хуучнаар цэцэрлэгийн барилга үлдсэн байдаг.

Тус барилга нь 1960 оны үед барьж 1962 онд ашиглалтад оруулсан бетон суурьтай, модон болон тоосгон өрөгт ханатай, модон шал, модон хучилттай, вакуум болон модон цонхтой, инженерийн шугам сүлжээнд бүрэн холбогдсон, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгүй, газрын гэрчилгээтэй, худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалт бүхий 483 кв талбай бүхий барилга юм.

Одоогоор Мэдээлэл холбооны сүлжээ компанийн төв байрын 4 дүгээр давхарт МЦХ ХК-ийн нийт 7 газар 8 албаны нийт 154 ажилтан конторлож, зарим өрөөнд 1 ширээн дээр 2 ажилтан сууж ажиллаж байна. Өнгөрсөн 16 жилийн хугацаанд МЦХ ХК нь МХС ХХК-д байр талбайн түрээсийн төлбөрт 2021 оны байдлаар 8.7 тэрбум төгрөгийг төлөөд байна.

2006 онд Монголын цахилгаан холбоо ХК-ийг салгахад тус компанид үлдсэн цэцэрлэгийн барилгын зүүн талаас харуулсан зураг байна, хойд талаас харуулсан зураг байна, барилгын баруун талаас нь урд талаас нь харуулсан хэсгүүд байна. Дотор талдаа энэ, барилгын өөрийнх нь насжилт гүйцсэн учраас жил бүр засвар хийж, дээвэр болоод, ханыг янзалдаг

боловч барилгын өөрийн насжилтаас болж хуурч унах, шавар нь ховхрох байдал байнга давтагдаж байгаа. Үүнтэй холбоотойгоор барилгыг Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч, Нийслэлийн мэргэжлийн хяналт зэрэг холбогдох байгууллагуудад хүсэлт гаргаж тухайн газруудаас дүгнэлтүүд гаргасан байгаа.

Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагчийн 2006.10.19-ний өдрийн 07/394/112 дугаар дүгнэлт: - Газар хөдлөлтийн эсрэг арга хэмжээг анхнаасаа тооцоогүй, хийц бүтээцийн одоогийн төлөв байдал нь “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22.01.01/2006”-ийн шаардлага хангахгүй,

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012.01.12-ны өдрийн 07-04/71 дугаартай дүгнэлт: “Барилгын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 заалт “Хүн ажиллаж, амьдрах таатай нөхцөл бүрдүүлсэн, түүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, аюулгүй байдлыг хангасан байх” шаардлага зөрчигдөж байна.

Иймд барилгад давхар нэмэх боломжгүй ба задлан буулгах тохиолдолд асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэн орчин үеийн болон хот төлөвлөлтийн шаардлагад нийцсэн барилга барих шаардлагатай гэж үзэж байна гэж тус тус дүгнэсэн байгаа.

Иймээс компанийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан уг үл хөдлөх хөрөнгийг актлан буулгаж хөрөнгийг данснаас хасаж тухайн хөрөнгийн эзлэх талбайд буюу 483 мкв газарт компанийн оффисын болон худалдаа үйлчилгээний зориулалт бүхий барилгыг барих саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулж байна.

С.Нямбаяр, хурлын дарга: Үүгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үндсэн хэлэлцэх долоон асуудал танилцуулагдаж дууслаа. Хурлын дэгээр, хувьцаа эзэмшигчдийнхээ санал авах, асуултад хариулах 30 минут байгаа. Асуулт хариулыг хурлын Zoom програмын цонхны Reaction цэсээс Race hand гар өргөх команд байгаа. гар өргөх командаа сонгоод санал хэлэх, асуулт асуух болно. Хамгийн түрүүлж гараа өргөсөн хувьцаа эзэмшигчдээсээ эхлэн асуултаа асууж, санал сонсьё. Гар утаснаас орж байгаа хувьцаа эзэмшигчдийн хувьд More гэсэн цэс байгаа. Уг цэсэнд Race hand гэсэн команд байгаа. Цэсээс гар өргөх команд сонгох боломжгүй бол програмынхаа чатаар бичээд асуулт асууж болно оо.

Асуулт хариулт, санал:

Төрийн өмчийн төлөөлөл, (В.Дарханбаатар): Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж буй асуудлын талаар нэг санал байна. Гол санал нь бол үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой долоо дугаар асуудлын шийдвэрийн төсөл нь өөрчлөх шаардлагатай гэж үзсэн. Ялангуяа энэ үл хөдлөх хөрөнгө актлах данснаас хасах тухай асуудлыг. Хувьцаа эзэмшигчдэд тараагдсан Монголын цахилгаан холбоо хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл зургаар бид тогтоолын төслийг өөрчлөн гаргах, хувьцаа эзэмшигчийн зүгээс тогтоолын төсөл санал болгож байгаа. Энд, 1-р заалтад “Монголын цахилгаан холбоо ХК-ийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгөөс хасахаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 178 дугаар хурлын 5 дугаар тогтоолыг баталсугай” гээд байгаа. Энэ 5 дугаар тогтоол нь ямар тогтоол байна вэ гэхээр энэ нь үл хөдлөх хөрөнгийг актлах, данснаас хасах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг даалгасан тогтоол байгаа. Энэ нь хууль зүйл хувьд шийдвэрлэх боломжгүй юм. Тийм учраас үл хөдлөх хөрөнгө актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай тогтоолын төсөл санал болгож байна. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. “Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, 62.1.16 дахь хэсэг,

Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол, “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн дүрмийн 7.1 дэх заалт, 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь;

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 261,398,226.52 (хоёр зуун жаран нэгэн сая, гурван зуун ерэн найман мянга, хоёр зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Компанийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, чөлөөлсөн газрыг “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн оффиссын болон үйлчилгээний зориулалтаар ашиглах, газрыг нөхөн сэргээх;

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д даалгах” ийм тогтоолын төслийг санал болгож байна.

С.Нямбаяр, хурлын дарга: За санал хэллээ. Өөр хувьцаа эзэмшигчдээс санал хэлж, асуулт асуух хувьцаа эзэмшигч байхгүй байгаа учраас дараагийн асуудал руугаа шилжье. Одоо Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар санал хураалт явуулах Тооллогын комисс санал хураалтаа явуулъя. Саналыг мөн програмаар явуулж байгаа. Өмнө танилцуулсан санал өгөх програм хангамжийн зааврын дагуу 5 минутын хугацаанд саналаа өгнө. Санал өгч дууссаны дараа хурлын завсарлага буюу тооллогын комисс маань дүнгээ гаргах ажил 15 минут завсарлана.

С.Нямбаяр, хурлын дарга: Хурлаар хэлэлцэх асуудлаар санал хурааж дууслаа. Тооллогын комисс санал хураалтыг дүнг нэгтгэж гарсан байна. Одоо тооллогын комиссын тогтоолыг тооллогын комиссын дарга Ганцэцэг танилцуулна.

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

С.Нямбаяр, хурлын дарга: 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулан хурлыг хаав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 24,499,464 ширхэг хувьцаа эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 11 саналын хуудас хүчинтэй, саналын хуудас хүчингүй байхгүй байна.

Саналын хуудсанд 6 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлийн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай 1-р асуудалд

Зөвшөөрсөн 11 санал, 100 хувиар буюу 24,499,464 ширхэг хувьцаа

Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу 0 ширхэг хувьцаа

2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай 2-р асуудалд

Зөвшөөрсөн 11 санал, 100 хувиар буюу 24,499,464 ширхэг хувьцаа

Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу 0 ширхэг хувьцаа

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай 3-р асуудалд

Зөвшөөрсөн 11 санал, 100 хувиар буюу 24,499,464 ширхэг хувьцаа

Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу 0 ширхэг хувьцаа

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай 4-р асуудалд
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс

1. А.Молор 24,499,464 ширхэг хувьцааны санал 100 хувь
2. Ж.Тамир 24,499,464 ширхэг хувьцааны санал 100 хувь
3. Ю.Бат-Эрдэнэ 24,499,464 ширхэг хувьцааны санал 100 хувь
4. Ц.Норовжамц 24,499,464 ширхэг хувьцааны санал 100 хувь

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай 5-р асуудалд

Зөвшөөрсөн 11 санал, 100 хувиар буюу 24,499,464 ширхэг хувьцаа

Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу 0 ширхэг хувьцаа

6. Үл хөдлөх хөрөнгө данснаас хасах, шинээр олж авах тухай 6-р асуудалд

Зөвшөөрсөн 11 санал, 100 хувиар буюу 24,499,464 ширхэг хувьцаа

Татгалзсан 0 санал, 0 хувиар буюу 0 ширхэг хувьцаа

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч батлав.
2. Компанийн 2021 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
 - i. Нийт хөрөнгийг 42,994,251,135.04 (дөчин хоёр тэрбум есөн зуун ерэн дөрвөн сая хоёр зуун тавин нэгэн мянга нэг зуун гучин таван) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 31,426,879,394.41 (гучин нэгэн тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая найман зуун далан есөн

- мянга гурван зуун ерэн дөрвөн) төгрөгөөр;
- ii. Өр төлбөрийн нийт дүнг 8,501,803,844.32 (найман тэрбум таван зуун нэгэн сая найман зуун гурван мянга найман зуун дөчин дөрвөн) төгрөгөөр;
 - iii. Эзэмшигчийн өмчийг 34,492,447,290.72 (гучин дөрвөн тэрбум дөрвөн зуун ерэн хоёр сая дөрвөн зуун дөчин долоон мянга хоёр зуун ерэн) төгрөгөөр.
- b. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
- a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.
- a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан А.Молорыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгов.
 - b. Ц.Шинэхүүг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
 - c. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.
5. ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
- a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны зардлын төсвийг Хавсралтаар батлав.
 - b. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.
6. Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
- a. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 261,398,226.52 (хоёр зуун жаран нэгэн сая, гурван зуун ерэн найман мянга, хоёр зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрөв.
 - b. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Б.Чинбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгав. Үүнд:
 - i. Компанийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор барилгыг

акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


- ii. Компанийн үл хөдлөх хөрөнгийг буулгаж, чөлөөлсөн газрыг “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн оффиссын болон үйлчилгээний зориулалтаар ашиглах, газрыг нөхөн сэргээх;
- с. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д, хэрэгжилтэд хяналт тавьж, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Т.Лхагвасүрэн)-д тус тус даалгав.

ТАНИЛЦСАН:



С.НЯМБАЯР, 2022 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2022 оны 5 дугаар сарын 02
Улаанбаатар хот.